



ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛИЙН ЭРДМИЙН ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2026 оны 06 сарын 12 өдөр

Дугаар 05

Улаанбаатар хот

“Оюуны өмчийн бодлого”-ын баримт бичиг батлах тухай

ШУТИС-ийн дүрмийн 4.9.1 дэх заалтууд, ШУТИС-ийн Эрдмийн зөвлөлийн журмын 3.2.1, 7.3, 7.5 дахь заалтууд, Эрдмийн зөвлөлийн гишүүдийн Нээлттэй санал хураалтын дүнг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. ШУТИС-ийн “Оюуны өмчийн бодлого”-ын баримт бичгийг хавсралтын дагуу баталсугай.

2. ШУТИС-ийн “Оюуны өмчийн бодлого”-ыг хэрэгжүүлэхтэй холбоотой ажлыг их сургуулийн хэмжээнд жил бүрийн ажлын төлөвлөгөө, санхүүгийн төсөвт тусгаж, гүйцэтгэл, үр дүнд хяналт тавьж ажиллахыг их сургуулийн бүтцийн бүх нэгжийн захирлуудад үүрэг болгосугай.

3. Бодлогын баримт бичгийг их сургуулийн профессор, багш ажилчдад таниулан сурталчлах үйл ажиллагааг зохион байгуулахыг Инновац, бизнес түншлэлийн алба, бүрэлдэхүүн сургуулиудад даалгасугай.

4. Дээрх бодлогын баримт бичгийг их сургуулийн хэмжээнд 2026 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдсүгэй.

ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

ЗӨВЛӨЛИЙН НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА



Т.НАМНАН

Д.ЦОЛМОНБААТАР

367210009



	ШУТИС-ийн Оюуны өмчийн талаар баримтлах бодлого ШУТИС-ОӨ-Б001	Эхний хэвлэлт	2026.06.12
		Өөрчилсөн огноо	-
		Өөрчлөлтийн дугаар	-

ШУТИС-ИЙН ОЮУНЫ ӨМЧИЙН БОДЛОГО

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1. Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн (цаашид “ШУТИС” гэх) Оюуны өмчийн бодлого (цаашид “Бодлого” гэх) нь ШУТИС-ийн багш, судлаачид, суралцагчдын сургалт, судалгаа, инновацын үйл ажиллагааны үр дүнд бий болсон оюуны өмчийг нээн илрүүлэх, хамгаалах, удирдах, эдийн засгийн эргэлтэд оруулах нэгдсэн тогтолцоог бүрдүүлэх зорилготой байна.
2. Энэхүү бодлогын зорилго, хэрэгжилт нь “Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030” Монгол Улсын Оюуны өмчийн тухай хууль, Патентын тухай хууль, Зохиогчийн эрхийн тухай хууль, Барааны тэмдэг, газар зүйн заалтын тухай хууль болон Оюуны өмчийн үндэсний стратеги, “ШУТИС-2030” стратеги төлөвлөгөөнд нийцсэн байна.
3. ШУТИС нь эх орны хөгжлийн гарцыг тодорхойлох хүн-байгальд ээлтэй шинжлэх ухаан, технологийн мэдлэг, инновацыг бүтээх авьяас чадварын төвлөрөл байх эрхэм зорилгын хүрээнд шинэ санаа, бүтээл, оюуны өмчийг хөгжлийн чухал хэрэгсэл гэж үзнэ.

ХОЁР. БОДЛОГЫН ХАМРАХ ХҮРЭЭ

- 2.1 Энэхүү бодлого нь дараах этгээдийн дор дурдсан үйл ажиллагааг хамарна.
 - 2.1.1 Бодлого нь дараах этгээдэд үйлчилнэ. Үүнд:
 - 2.1.1.1 ШУТИС-ийн багш, судлаач, ажилтан, суралцагч;
 - 2.1.1.2 Зочин профессор, гэрээт багш, судлаач, зөвлөх;
 - 2.1.1.3 ШУТИС-тай хамтарсан судалгаа, инновацын төсөл, гэрээт ажил хэрэгжүүлэгч гадаад, дотоод байгууллага, иргэн;
 - 2.1.1.4 ШУТИС-ийн судалгааны төв, гарааны компани;
 - 2.1.2 Энэхүү бодлого нь дараах үйл ажиллагааны үр дүнд бий болсон оюуны өмчид хамаарна. Үүнд:
 - 2.1.2.1 Сургалтын үйл ажиллагаа;
 - 2.1.2.2 Эрдэм шинжилгээ, судалгааны төсөл, гэрээт ажил, нэг сэдэвт бүтээл;
 - 2.1.2.3 Инновац, технологи хөгжүүлэлт, эх загвар бүтээл, туршилт;
 - 2.1.2.4 Дотоод, гадаадын байгууллагатай хамтарсан судалгаа, захиалгат ажил, олон улсын төсөл, хөтөлбөр;

ГУРАВ. БОДЛОГЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД БАРИМТЛАХ ЗАРЧИМ

- 3.1 Бодлогыг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална. Үүнд:
 - 3.1.1 ШУТИС-ийн багш, судлаач, ажилтан, суралцагч оюуны бүтээл бий болгох, оюуны бүтээлд эрхийн хамгаалалт хийлгэх, арилжаалахыг бүх талаар дэмжих;
 - 3.1.2 Оюуны бүтээлийг өмчлөх, ашиглахад зохиогч болон ШУТИС-ийн эрх ашгийн тэнцвэрт байдлыг хангах;
 - 3.1.3 Оюуны өмчийн удирдлага, зохион байгуулалт, ашиглалтын үйл ажиллагаанд нээлттэй, шударга ёсыг эрхэмлэх;



- 3.1.4 Оюуны бүтээл, оюуны өмчийн талаарх мэдлэг, мэдээллийг түгээн дэлгэрүүлэх, нийтэд ашиглах боломжийг бүрдүүлэхдээ тухайн бүтээлийн патент болон бусад хэлбэрийн эрхийн хамгаалалт хангагдсаны дараа хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэх;
- 3.1.5 Сургалт, судалгаа, инновацын үйл явцад бусдын оюуны өмчийг хүндэтгэх;

ДӨРӨВ. ОЮУНЫ ӨМЧИЙН ӨМЧЛӨЛИЙН ХАРИЛЦАА

- 4.1 Их сургуулийн сургалт, судалгаа, инновацын үйл ажиллагааны үр дүнд бий болсон оюуны өмчийг эзэмших, өмчлөх онцгой эрхийн харилцаанд дараах бодлогыг баримтална:
 - 4.1.1 Доорх нөхцөлд бий болсон оюуны өмчийг эзэмших онцгой эрх нь ШУТИС байх бөгөөд ШУТИС нь тухайн оюуны өмчийг дангаар эсвэл зохиогч, зохион бүтээгчтэй хамтран эзэмшиж болно. Үүнд:
 - 4.1.1.1 ШУТИС-тай байгуулсан хөдөлмөрийн гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх явцад зохион бүтээсэн оюуны өмч;
 - 4.1.1.2 Их сургуулийн санхүүжилтээр хийгдсэн төсөл, судалгааны үр дүн
 - 4.1.1.3 Их сургуулийн лаборатори, тоног төхөөрөмж, санхүүгийн болон бусад материаллаг нөөцийг ашиглан бий болгосон оюуны өмч;
 - 4.1.1.4 Ажил олгогчийн өгсөн албан даалгаврыг биелүүлэх явцад зохион бүтээсэн оюуны өмч;
 - 4.1.1.5 Улсын төсвийн санхүүжилтээр гүйцэтгэсэн эрдэм шинжилгээ, туршилт, зохион бүтээх ажлын гүйцэтгэгч нь ШУТИС бөгөөд төсөл хэрэгжүүлэх гэрээнд өөрөөр заагаагүй бол төсөл, гэрээт ажлын хүрээнд бий болсон оюуны өмч;
 - 4.1.1.6 Зохион бүтээгч сайн дурын үндсэн дээр эрх эзэмшигчийг их сургуулийг дангаар эсвэл хамтран эзэмшүүлэхээр санал гаргаж 4.3-т дурдсаны дагуу тохиролцсон.
- 4.2 Энэхүү бодлогын 4.1.1 дэх хэсэгт зааснаас бусад нөхцөлд бий болсон оюуны өмчийн эзэмшигч нь тухайн бүтээлийн зохиогч, зохион бүтээгчийн өмч байна.
- 4.3 Бодлогын 4.1.1 дэх хэсэгт хамаарах нөхцөл үүсээгүй оюуны бүтээлийг зохиогчийн хүсэлтээр их сургуулийн эзэмшилд бүртгүүлэх тохиолдолд бүрэлдэхүүн сургууль, нэгжийн эрдмийн зөвлөлөөр хэлэлцүүлсэн байна.
- 4.4 Хамтарсан судалгааны үр дүнд бий болох оюуны өмчийг талуудын хооронд байгуулсан гэрээгээр нарийвчлан зохицуулна.
- 4.5 Хиймэл оюунд суурилсан бүтээлийн зохицуулалтыг их сургуулийн өгөгдлийн засаглалтай холбогдох бодлогын дагуу шийдвэрлэнэ.
- 4.6 Их сургуулийн эзэмшиж буй оюуны өмчийг эдийн засгийн эргэлтэд оруулснаас олсон роялти орлогыг дараах байдлаар хуваарилна.

Зохиогч, зохион бүтээгч	Зохиогч, зохион бүтээгчийн харьяалах сургууль (тэнхим)	Их сургууль
55%	20%	25%

- 4.7 Оюуны өмчийг ашиглуулах лицензийн гэрээний үндсэн дээр роялти орлогын хэмжээг тогтооно.



- 4.8 ШУТИС нь багш, судлаач, суралцагчдын зохиогчийн эрхэд хамаарах бүтээлийн (ном, сурах бичиг, өгүүлэл, төгсөлтийн ажил, диссертаци гэх мэт) зохиогчийн эрхийг хүндэтгэн, зохих зөвшөөрөл болон нээлттэй хандалтын (Open Access) нөхцөлийн хүрээнд номын сан, мэдээллийн санд хадгалж, сургалт, судалгааны зорилгоор ашиглуулах эрхтэй байна.
- 4.9 Захиалагч байгууллагатай байгуулсан “Нууцлалын гэрээ”-ээр хязгаарлалт тогтоосон бол гэрээнд заасан хугацаанд 4.8 дахь хэсэгт заасны дагуу нийтэд нээлттэй байршуулахыг хориглоно.

ТАВ. СУРАЛЦАГЧИЙН ОЮУНЫ ӨМЧ

- 5.1 Суралцагчийн дипломын ажил, докторын диссертаци, төсөл болон судалгааны ажил нь тухайн суралцагчийн оюуны бүтээлд тооцогдоно.
- 5.2 Суралцагч өөрийн бүтээлдээ зохиогчийн эрх эдэлнэ.
- 5.3 Дараах тохиолдолд тухайн суралцагчийн судалгааны ажлын үр дүнд бий болсон оюуны өмчийг ШУТИС дангаар буюу зохиогчтой хамтран эзэмшиж болно.
 - 5.3.1 Суралцагчийн судалгаа нь их сургуулийн санхүүжилттэй судалгааны төсөлд хамаарах оюуны өмч;
 - 5.3.2 Их сургуулийн лаборатори, тоног төхөөрөмж бусад нөөцийг ашиглан бүтээсэн оюуны өмч;
 - 5.3.3 Байгууллагатай хамтарсан судалгааны гэрээний хүрээнд бий болсон оюуны өмч;
- 5.4 Суралцагч нь төгсөлтийн ажил, диссертаци, төслийн хүрээнд программ хангамжийн эх код, бүтээл туурвихдаа ашигласан нээлттэй эхийн лицензийн нөхцөлийг бүрэн хангасан байх үүрэгтэй.
- 5.5 Суралцагч төгсөлтийн ажлаа хамгаалахаас өмнө их сургуулийн оюуны өмч, технологи дамжуулалтын нэгжээс баталсан холбогдох маягыг бөглөж, удирдагч багшаар баталгаажуулна.
- 5.6 Оюуны өмчийн эрхтэй холбоотой аливаа маргаан, зөрчил гарсан тохиолдолд суралцагч зохиогчийн хувиар хуулийн хариуцлагыг бүрэн хүлээнэ.
- 5.7 Удирдагч багш нь суралцагчийн бүтээлийн техникийн шийдэл, аргачлалыг боловсруулахад биечлэн оролцож бүтээлч хувь нэмэр оруулсан нь нотлогдсон тохиолдолд хамтран зохиогчоор бүртгэгдэх бөгөөд зөвхөн ерөнхий арга зүйн зөвлөгөө өгсөн, удирдан чиглүүлсэн үйлдэл нь хамтран зохиогч болох үндэслэл болохгүй.
- 5.8 Суралцагч дипломын ажлынхаа үр дүнгээр патент авах, гарааны бизнес байгуулах тохиолдолд ШУТИС-ийн оюуны өмч, технологи дамжуулалтын асуудал хариуцсан нэгжтэй лицензийн гэрээний үндсэн дээр хамтран ажиллана.

ЗУРГАА. АШИГ СОНИРХЛЫН ЗӨРЧЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ

- 6.1 Багш, судлаач, суралцагч нь их сургуулийн эзэмшлийн оюуны өмчийг ашиглан гарааны компани байгуулах, эсвэл гуравдагч этгээдтэй хамтран ажиллах тохиолдолд ашиг сонирхлын зөрчил үүсээгүй тухай оюуны өмчийн эзэмшигч болон гуравдагч талуудад бичгээр мэдүүлэх үүрэг хүлээнэ.
- 6.2 Их сургуулийн нөөц боломж (лаборатори, тоног төхөөрөмж, программ хангамж, мэдээллийн сан г.м)-ийг арилжааны зорилгоор ашиглахдаа их сургуультай байгуулсан гэрээний үндсэн дээр ажиллах бөгөөд сургалт, судалгааны үндсэн үйл ажиллагааг тасалдуулахгүй байх зарчмыг баримтална.



6.3 Багш, судлаач, суралцагч нь гаднын санхүүжилттэй төсөл гэрээт ажил гүйцэтгэхдээ их сургуулийн оюуны өмчийг ашиглах бол тухайн өмчлөлийн эрхийн зааг ялгааг гэрээгээр тодорхойлж, их сургуулийн эрх ашгийг хохироохгүй байх үүрэг хүлээнэ.

ДОЛОО. БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ

- 7.1 ШУТИС-ийн оюуны өмчийн бодлого, эрх зүйн таатай орчныг боловсронгуй болгох зорилтын хүрээнд:
- 7.1.1 Оюуны өмчийн харилцааг зохицуулах журам, зааврыг боловсронгуй болгон баталгаажуулж хэрэгжилтийг зохион байгуулна;
 - 7.1.2 Оюуны өмчийн бодлого, төлөвлөлт, хэрэгжилтийг шинжлэх ухаан, технологи, инновац, дээд боловсролын хөгжлийн хандлагатай уялдуулан нэгдсэн арга зүй, удирдлагаар хангана;
 - 7.1.3 Оюуны өмчийн үйл ажиллагаа, харилцаанд гадаад, дотоод хамтын ажиллагааг үр дүнтэй хөгжүүлнэ;
- 7.2 Багш, судлаачид, суралцагчдын оюуны бүтээл туурвих, шинийг санаачлах үйл ажиллагааг дэмжих зорилтын хүрээнд:
- 7.2.1 Шинийг санаачлагч, зохион бүтээгч, уран бүтээлчийг дэмжих, урамшуулах тогтолцоог боловсронгуй болгож, шилдэг оюуны өмчийн бүтээл, шинэ санааг олон нийтэд түгээн дэлгэрүүлэх тогтолцоог бүрдүүлнэ;
 - 7.2.2 ШУТИС-ийн судалгааны тэргүүлэх чиглэлийн хүрээнд оюуны өмч бий болгоход чиглэсэн үйл ажиллагааг дэмжиж, оюуны өмчийг анхан шатанд илрүүлэх, бүртгэх, мэдээлэх соёлыг төлөвшүүлнэ;
 - 7.2.3 Сургалт, судалгаа, инновацын үйл ажиллагаанд патентын мэдээллийг ашиглах тогтолцоог нэвтрүүлнэ;
- 7.3 ШУТИС-ийн оюуны өмчийн ашиглалтыг нэмэгдүүлэх, үйлдвэрлэлд нэвтрүүлэх, эдийн засгийн эргэлтэд оруулах зорилтын хүрээнд:
- 7.3.1 Технологийн бэлэн байдлын түвшин (TRL)-д суурилсан үнэлгээ, шийдвэр гаргалтыг нэвтрүүлэх замаар эдийн засгийн үр ашигтай оюуны өмчийг тэргүүн ээлжид үйлдвэрлэлд нэвтрүүлэх, хамгаалах ажлыг дэмжинэ;
 - 7.3.2 Оюуны өмчийн лицензийн тогтолцоог боловсронгуй болгоно;
 - 7.3.3 ШУТИС-ийн дэргэд технологи, ноу-хау, оюуны өмчид түшиглэсэн гарааны компаниудыг байгуулж хөгжүүлнэ;
- 7.4 Оюуны өмчийн менежмент, зохион байгуулалтыг боловсронгуй болгох зорилтын хүрээнд:
- 7.4.1 Оюуны өмчийн статистик мэдээг олон улсын стандартын дагуу гаргах, их сургуулийн хөгжлийн төлөвлөлт, бодлого боловсруулахад оюуны өмчийн үйл ажиллагааны үр дүнг ашиглах тогтолцоог бүрдүүлнэ;
 - 7.4.2 ШУТИС-ийн сургалт, судалгаа, инновацын үйл ажиллагааны үр дүнд бий болсон оюуны өмчийн нэгдсэн мэдээллийн санг бүрдүүлнэ.
 - 7.4.3 ШУТИС-ийн оюуны өмчийн менежментийн тогтолцоонд оролцогч талууд (бүрэлдэхүүн, харьяа сургууль, нэгж, удирдлага)-ын хүний нөөцийг оюуны өмчийн менежментийн үйл ажиллагааны чиглэлээр мэргэшүүлж хөгжүүлнэ.
 - 7.4.4 Биологийн гаралтай материал, бичил биетний өсгөвөр, генетик нөөц, омог зэрэг судалгааны материал ашиглалт, хадгалалт, дамжуулалтыг холбогдох хууль, тогтоомж болон олон улсын гэрээний шаардлагад нийцүүлэн зохицуулах ба шаардлагатай тохиолдолд материал дамжуулах гэрээг байгуулан ажиллана.



НАЙМ. БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТИЙН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

- 8.1 Энэхүү бодлогын хэрэгжилт нь оюуны өмчийг бий болгох, илрүүлэх, хамгаалах, удирдах, эдийн засгийн эргэлтэд оруулах нэгдсэн, уялдаатай үйл явцад суурилна.
- 8.2 Бодлогын хэрэгжилтийг дараах нэгжүүдийн уялдаа холбоонд тулгуурлан зохион байгуулна:
- 8.2.1 Эрдмийн зөвлөлийн дэргэдэх эрдэм шинжилгээ, инновацын дэд зөвлөл нь бодлогын хэрэгжилтийг их сургуулийн стратеги төлөвлөлттэй уялдуулан бодлогын түвшинд удирдан чиглүүлж, үр дүнд дүгнэлт өгнө;
- 8.2.2 Эрдэм шинжилгээ, инновацын асуудал эрхэлсэн удирдлага нь бодлогын хэрэгжилтийг их сургуулийн хэмжээнд нэгдсэн удирдлагаар хангаж, холбогдох нэгжүүдийн үйл ажиллагааг уялдуулан зохицуулна.
- 8.2.3 Оюуны өмч, инновац, технологи дамжуулалтын чиг үүрэг бүхий нэгж нь оюуны өмчийг нэгдсэн санд бүртгэх, хамгаалах, эдийн засгийн эргэлтэд оруулах үйл ажиллагааг хэрэгжүүлэх үндсэн гүйцэтгэгч нэгж байна;
- 8.2.4 Бүрэлдэхүүн болон харьяа сургуулийн эрдэм шинжилгээ, инновацын асуудал эрхэлсэн нэгж нь оюуны өмчийг анхан шатны түвшинд маягтын дагуу бүртгэн, эдийн засгийн эргэлтэд оруулах асуудалтай холбоотой мэдээллээр багш, судлаачдыг хангаж ажиллана;

ЕС. БОДЛОГЫН ХҮРЭХ ҮР ДҮН, ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

- 9.1 Энэхүү бодлогыг үр дүнтэй удирдан зохион байгуулж, дараах үр дүнд хүрнэ.

№	Хүрэх үр дүн, шалгуур	Хэмжих үзүүлэлт	2026 он (суурь)	2028 он	2030 он
1	Их сургуулийн эзэмшилтэй аж үйлдвэрийн оюуны өмчийг нэмэгдүүлнэ.	Их сургуулийн эзэмшилтэй аж үйлдвэрийн оюуны өмчийн тоо	40	63	100
2	Үйлдвэрлэлд технологи нэвтрүүлсэн их сургуулийн эзэмшилтэй оюуны өмчийг үнэлж, зохион бүтээгчдэд роялти олгох тогтолцоог бүрдүүлнэ.	ШУТИС-ийн эрдэм шинжилгээ, инновацын орлогод роялти орлогын эзлэх хувь	0.36%	0.81%	1.6%
3	Оюуны өмчийг эдийн засгийн эргэлтэд оруулж, технологи арилжаалалтыг нэмэгдүүлнэ.	Лицензийн гэрээний тоо	10	16	50

- 9.2 Бодлогын хэрэгжилтийг дараах үндсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд ахиц дэвшлийг хэмжиж ажиллана.

- 9.2.1 Оюуны өмчийн анхан шатны мэдүүлгийн тоо
- 9.2.2 Судалгааны төслөөс бий болсон оюуны өмчийн тоо
- 9.2.3 Диплом, диссертациас бий болсон инновацын шийдлийн тоо
- 9.2.4 Жилд гаргасан патентын мэдүүлгийн тоо
- 9.2.5 Олгогдсон патентын тоо
- 9.2.6 Зохиогчийн эрхийн бүртгэлийн тоо
- 9.2.7 Байгуулсан лиценз, технологи дамжуулах гэрээний тоо



- 9.2.8 Үйлдвэрлэлд нэвтрүүлсэн технологийн тоо
- 9.2.9 Байгуулагдсан гарааны компанийн тоо
- 9.2.10 Оюуны өмчийн арилжаалалт (лиценз, технологи дамжуулалт)-ын роялти орлогын хэмжээ
- 9.2.11 Оюуны өмч, технологи дамжуулалтын сургалтад хамрагдсан багш, судлаачдын тоо

АРАВ. БОДЛОГЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ САНХҮҮЖИЛТ

- 10.1 Бодлогын хүрээнд төлөвлөсөн оюуны өмчийг нээн илрүүлэх, бүртгэх, хамгаалах, удирдах, эдийн засгийн эргэлтэд оруулах үйл ажиллагааг дараах эх үүсвэрээс санхүүжүүлнэ:
 - 10.1.1 Их сургуулийн төвлөрсөн төсөв: Бүрэлдэхүүн болон харьяа сургуулиуд жил бүр оюуны өмчийг хамгаалах, улсын тэмдэгтийн хураамж, патентын итгэмжлэгдсэн төлөөлөгчийн зардлыг төсөвт тусгах;
 - 10.1.2 Төсөл, гэрээт ажлын гэрээний санхүүжилт: Улсын төсөв болон гадаад, дотоодын төсөл хэрэгжүүлэх гэрээнд оюуны өмчийг хамгаалах зардлыг тусгайлан тусгах;
 - 10.1.3 Оюуны өмчийн арилжаа, шимтгэлийн орлого: Лицензийн гэрээ болон роялти орлого, төсөл, гэрээт ажлын шимтгэлийн тодорхой хувийг оюуны өмчийн менежмент, технологи дамжуулалтын үйл ажиллагааг дахин санхүүжүүлэхэд зарцуулах;
 - 10.1.4 Хандивын сан:(Endowment fund): Их сургуулийн урт хугацааны хөгжлийн бодлогыг санхүүжүүлэх чиглэлийн хүрээнд оюуны өмчийн тогтолцоог бүрдүүлэх үйл ажиллагаанд зарцуулах зардал;

АРВАН НЭГ. БОДЛОГЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ХУГАЦАА

- 11.1 Энэхүү бодлого нь ШУТИС-ийн урт хугацааны хөгжлийн зорилт “ШУТИС-2030” стратеги төлөвлөгөөний нэг хэсэг бөгөөд 2030 он хүртэл тасралтгүй хэрэгжинэ.
 - 11.1.1 Оюуны өмчийн бодлогыг хэрэгжүүлэх үе шат:
 - I шат (2026-2028 он): Оюуны өмчийг нээн илрүүлэх, бүртгэх нэгдсэн тогтолцоо, мэдүүлэх механизмыг бүрэн хэвшүүлэх үе;
 - II шат (2028-2030 он): Оюуны өмчийг арилжаалах, лицензлэх, гарааны компаниудын тоог нэмэгдүүлэх замаар эдийн засгийн үр өгөөжийг тогтворжуулж, өсөлт бий болгох үе;
- 11.2 Бодлогын хэрэгжилтийн явц болон хууль эрх зүйн орчны өөрчлөлттэй уялдуулан 2 жил тутамд бодлогод нэмэлт өөрчлөлт, шинэчлэл хийж болно.

АРВАН ХОЁР. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ

- 12.1 Бодлогын хэрэгжилтийн явц, үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх асуудлыг их сургуулийн хяналт-шинжилгээ хариуцсан нэгж 2 жил тутам дараах байдлаар зохион байгуулна.
 - 12.1.1 Бодлогын хэрэгжилтийг батлагдсан хүрэх үр дүнгийн шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлнэ.
 - 12.1.2 Үйл ажиллагааны хэрэгжилтийг ахиц дэвшлийн үзүүлэлтээр дүгнэнэ.

ШУТИС-ийн Эрдмийн зөвлөлийн 2026 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн 108 дугаар тогтоолын хавсралт



- 12.1.3 Бүрэлдэхүүн нэгжүүдээс ирүүлсэн тайланг нэгтгэн харьцуулсан шинжилгээ хийнэ.
- 12.2 Бодлогын хэрэгжилтийн 2 жил тутмын тайланг Эрдмийн зөвлөлийн дэргэдэх эрдэм шинжилгээ, инновацын дэд зөвлөлд танилцуулна.
- 12.3 Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүнд үндэслэн сайжруулах арга хэмжээг төлөвлөж бүрэлдэхүүн нэгжийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлнэ.

--oOo--